

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№18/479

ШУС, НУС

2017

АНАЛИТИК СЭТГҮҮЛ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ЗАРИМ АСУУДАЛД

М.Зулькафиль*, Х.Батхишиг**

*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D)

**МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

Түлхүүр үг: аналитик сэтгүүл зүй, “шар” хэвлэл, мэдээллийн нийгэм, логикийн арга, танин мэдэхүйн объект, эх сурвалж, төрөл зүйл, агуулга хэлбэр

Ардчилсан нийгэмд шилжиж, чөлөөт сэтгүүл зүйн эх суурь тавигдсанаас хойш Монголын сэтгүүл зүйд гарсан томоохон өөрчлөлтийн нэг бол сэтгүүлчийн ур чадварт гарсан өөрчлөлт юм. Мэдээж сэтгүүлчийн ур чадварт эерэг ч, сөрөг ч өөрчлөлт гарсан нь тодорхой. Энэ удаа тэдний дундаас зөвхөн нэгийг буюу олон улсын сэтгүүл зүйн практикт аналитик сэтгүүл зүй гэж нэрлэгддэг “сэтгүүлчийн уран бүтээлийн бие даасан төрөл”¹ -ийн талаар тогтож ярихыг зорилоо.

Нийгмийн өмнө тулгамдсан томоохон асуудал, үйл явдал, үзэгдэлд олон талаас нь дүн шинжилгээ хийж, сонгож авсан цогц баримтыг задлан шинжилж, нэгтгэн дүгнэх замаар тэдний дотоод мөн чанарт нэвтэрч, шалтгаан үр дагаврыг дэлгэн тавьдаг сэтгүүл зүйн чиглэлийг аналитик

сэтгүүл зүй гэж нэрлэдэг нь түгээмэл юм. Орчин үеийн Монголын сэтгүүл зүйд энэ чиглэл өөрийн гэсэн байрыг эзэлж, хүлээн авагчдыг байлдан дагуулж чадаагүй байгаа нь тодорхой. Үүнийг мэргэжлийн сэтгүүлч, судлаач төдийгүй жирийн уншигч хүртэл зуун хувь хүлээн зөвшөөрдөг. Харин өмнөх үеийн сэтгүүл зүйтэй харьцуулахад томоохон ухралт хийсэн гэж хэлэх хүн ч цөөнгүй тааралддаг.

Ер нь өнөөгийн сэтгүүл зүйн нийтлэл, нэвтрүүлэгт ямар ч асуудалд хэт өнгөцхөн хандсан, арай хүндэвтэр, шийдвэрлэх шаардлагатай асуудлыг тойрч гарсан, сайндаа өөрийнхөө үзэл бодолд тулгуурлан мэдээлэх төдий зорилгоор хязгаарлагдсан бүтээл хэт олширсон нь ажиглагддаг. Нийгэм, эдийн засаг, улс төр, соёл урлаг, боловсролын тулгамдсан асуудлуудыг сонгон авч түүнд ул суурьтай дүн шинжилгээ хийж, оршиж буй дутагдал доголдлыг зоригтой илрүүлж, хурцаар шүүмжилсэн, хэтийн төлвийг тодорхойлсон, шийдвэрлэх арга замыг эрж хайсан шинжлэлт буюу аналитик

нийтлэл өдрийн од шиг ховор байна. Энэ нь олон шалтгаантай.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо хэт олширч бараг хүссэн хүн бүхэн түүнийг эрхлэн гаргаж, сэтгүүл зүйн ажил хүн болгонд хүртээмжтэй, дэндүү амар хялбар, гарын үзүүрээр хийх ажил болон хувирсан. Хэвлэл мэдээллийн салбарт асар их мэргэжлийн бус хүн ажиллах болж, тэд сэтгүүл зүйн нийгмийн үүрэг байтугай сэтгүүл зүйн талаарх анхны мэдэгдэхүүнгүй байгаа нь түүнийг зөвхөн мөнгө олох хэрэгсэл төдий ойлгох явдал газар авсан. Өөрөөр хэлбэл нийгмийн мэдээлэл гэдэг зүйлийг зөвхөн таваар, бизнесийн хэмжээнд л сэтгэх хандлага өргөн дэлгэрсэн юм.

Мэдээллийн зах зээлд дэндүү олон хэвлэл мэдээллийн хэрэгсэл оршин тогтох болсон нь мэдээллийн төлөө өрсөлдөөнийг бий болгож, энэ нь мэдээллийн шуурхай чанарт хүчтэй нөлөөлж эхэлсэн. Энэхүү шуурхай байдал хэмээх далбаан дор цаг үеийн шинжтэй болон элдэв дуулиан шуугиан дэгдээсэн “шар” мэдээний араас хэт хөөцөлдөх явдал газар авч, ашиг орлогын төлөө олон нийтийн сэтгэл зүйгээр тоглохыг тэргүүн зэрэгт тавих болсон. Товчоор хэлбэл хэвлэл мэдээллийн аль ч хэрэгсэлд арилжааны шинж нэвт шингэж, Монголын сэтгүүл зүйд бүхэлдээ “шарлах” хандлага гол байр эзэлж, ХМХ-ийн эздийн, сэтгүүлчдийн үзэл бодол давамгайлах нь энгийн үзэгдэл болон хувирсан. Энэ бүхний үр дүнд мэдээллийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй сонинууд чанартай, завсрын, “шар” сонин гэсэн гурван томоохон хэсэгт хуваагдсан.

Хүлээн авагчдад ач холбогдолтой, үнэн бодитой мэдээллийг түгээхийг зорилго болгодог чанартай буюу элитар сонины тоо аажим аажмаар нэмэгдэж, ийм шинжийг түлхүү агуулсан өдөр тумын сонины тоо 16 хүрч, танин мэдэхүйн шинж давамгайлсан долоо хоногийн сонины тоо тогтвортой байна. Холимог буюу завсрын гэж нэрлэгддэг чанартай болон зугаацуулах шинжтэй материалуудын аль алиныг түлхүү нийтэлдэг сонины тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж, харин “шар” сонины тоо багасах хандлагатай байна. Гудамжны “шар” хэвлэл гэж нэрлэгддэг олон нийтэд зориулагдсан, зугаацуулах шинжийг гол зорилгоо болгодог, хүлээн авагчдын сэтгэл зүйгээр тоглохыг тэргүүн байранд тавьдаг сонины тоо багасах хандлагатай боловч манай орны мэдээллийн зах зээлд баттай байр эзэлсэн хэвээр байна.

Бидний дээр дурдсан завсрын болон “шар” сонинуудад аналитик материал огт нийтлэгдэхгүй гэж хэлж болно. Харин чанартай гэж нэрлэгддэг өдөр тутмын сонинд нийтлэгддэг аналитик материалын тоо хэт цөөн, бас чанарын хувьд тааруу, аналитик сэтгүүл зүйд тавигдах шаардлагыг тэр бүр хангаж чадахгүй байгаа нь ажиглагддаг. Өдрийн од шиг ховор боловч шинжлэлт сурвалжилсан тэмдэглэл, тойм, тайлан, ярилцлага, өгүүлэл, тайлбар, шүүмж гардгийг үгүйсгэж болохгүй. Ер нь аналитик нийтлэлээс хүлээн авагч чухам юу хүсэн хүлээдэг вэ? Үүнд хариулахын тулд аналитик нийтлэлийн үндсэн шинж, гол онцлогийг мэдэх шаардлагатай юм. Дээр дурдсан аналитик бичлэгийн төрөл зүйлээр бичигдсэн материалууд юуны өмнө

сонгож авсан үйл явдал, үзэгдлийн шалтгаан, үр дагаврыг гарган тайлбарлах, үйл явдлыг тал бүрээс нь харуулах, тэдний нийгмийн ач холбогдлыг үнэлж цэгнэх, нөхцөл байдлын цаашдын хөгжил, хэтийн төлвийн талаар таамаглал дэвшүүлэх, цаашид хийх алхмуудын талаар зөвлөх, хөндөж тавьсан асуудлыг шийдвэрлэх арга замыг эрж хайхыг зорилго болгодог онцлогтой.

Мэдээж уншигч аналитик нийтлэлээс чухам үүнийг хүсэн хүлээж байдаг нь тодорхой. Ингэх нь зүй ёсны хэрэг, учир нь орчин үеийн нийгмийн болон техник технологийн хөгжил, байнга өсөн нэмэгдэж буй хүмүүсийн мэдлэг боловсрол, ухамсар, соёлын түвшин, мэдээлэл олж авах боломж, даяаршлын үйл явц, амьдрах орчин, нөхцөл аливаа асуудалд өөр өөр хандахыг, түүний дотоод мөн чанарт нэвтэрч, учир шалтгааныг тайлахыг шаардах болсон. Үүнийг нааштай шийдвэрлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг сэтгүүл зүйн чиглэл бол аналитик сэтгүүл зүй мөн.

Орчин үеийн Монголын сэтгүүл зүйд аналитик сэтгүүл зүйн орон зай үгүйлэгдэх, манай хэвлэл мэдээллийн хэрэгслүүд тодорхой хугацаанд болж өнгөрсөн үйл явдлуудыг өнгөцхөн тоочин мэдээлэх, тоймлон өгүүлэх хандлага давамгайлсан хэвээр байна. Өөрөөр хэлбэл манай нийтлэл,

нэвтрүүлэгт ажил хэрэгч, товч тодорхой байх шинж дутмаг байна гэж хэлж болно. Нийтлэл, нэвтрүүлгийн ихэнх хэсгийг тухайн сэдэвтэй онцын холбогдолгүй оршил, хоосон тайлбар, үндэслэл муутай үнэлэлт, хэмжээнээс хэтэрсэн дүгнэлт эзэлдэг. Энэ бол чөлөөтэй сэтгэх, чөлөөтэй бичих гэсэн шалтгаанаар

асуудалд хэт задгай, өнгөцхөн хандаж, зохиогч өөрийнхөө үзэл бодлыг тулгах, асуудлын хэт нэг талыг барьж туйлшрах, өөрөөр хэлбэл мэдээллийн тэнцвэрт байдал алдагдах явдал түгээмэл ажиглагдах болсон. Энэ нь дараах хэдэн хүчин зүйлтэй холбоотой юм.

Нэгдүгээрт, манай нөлөө бүхий мэдээллийн хэрэгслүүдийн эзэд улс төрчид, томоохон бизнесменүүд, төр засгийн өндөр албан тушаалтнууд байгаагаас тухайн хэвлэл мэдээллийн хэрэгсэл эздийн болон тэднийг дэмжигч хэсэг, бүлэг хүмүүсийн үзэл бодлын индэр, дуу хоолой болж байна. Тиймээс сэтгүүлчид хүссэн, эс хүссэн ч тэдний үзэл бодлыг дагахаас өөр аргагүй буюу зарим судлаачийн хэлдэг шиг “бууны нохой” болохоос өөр аргагүй юм.

Хоёрдугаарт, хэвлэл мэдээллийн тоо олширч хоорондоо өрсөлдөөн бий болж, шуурхай хүртээмжтэй чанар дээшилсэн нь нэг талаар сэтгүүлчид шуурхай ажиллаж, богино хугацаанд

«

Орчин үеийн нийгмийн болон техник технологийн хөгжил, байнга өсөн нэмэгдэж буй хүмүүсийн мэдлэг боловсрол, ухамсар, соёлын түвшин, мэдээлэл олж авах боломж, даяаршлын үйл явц, амьдрах орчин, нөхцөл аливаа асуудалд өөр өөр хандахыг, түүний дотоод мөн чанарт нэвтэрч, учир шалтгааныг тайлахыг шаардах болсон. Үүнийг нааштай шийдвэрлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг сэтгүүл зүйн чиглэл бол аналитик сэтгүүл зүй мөн

»

харьцангуй олон мэдээ, баримт цуглуулах, цаг алдалгүй мэдээлэх зэрэг сайн талтай боловч, нөгөө талаар хүч хөдөлмөр, цаг хугацаа шаардах сэдвүүдийг барьж авч, судалгаа, даацтай дүгнэлт хийж, үнэлэлт өгч бичихээс зайлсхийж, асуудал дэвшүүлсэн, шүүмжлэлт өгүүлэл, сурвалжилсан тэмдэглэл зэрэг томоохон шинжлэлт бичлэгийн зүйлүүдийг тойрч гардаг болсон. Өөрөөр хэлбэл биеийн амрыг бодож, улиг болсон хэдэн мэдээллийн бичлэгийн зүйлийн хүрээнд эргэлддэг болжээ.

Гуравдугаарт, тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн редакцийн газраас сэтгүүлчдэд тавигдах шаардлага сул, сэтгүүлчдийн хөдөлмөрийг оновчтой хуваарилах, хорших буюу сэтгүүлчийн мэдлэг, чадвар, туршлагыг харгалзан ажлыг нь оновчтой зохион байгуулж чадахгүй байна. Редакцийн газруудын удирдлагад бага мөнгө төлж их юм хийлгэх, болж өгвөл бараг үнэгүй ажлаа хийлгэх гэсэн сэтгэлгээ давамгайлсан хэвээр байна. Энэ бол редакцийн газрын менежменттэй шууд холбоотой асуудал бөгөөд сэтгүүлчид өөрсдийн нөөц боломж, авьяас чадварыг бүрэн дайчилж ажиллахад нөлөөлөх тогтолцоо үгүйлэгдэж байна гэсэн үг юм. Хэрэв чанартай сайн материал бичсэн, бэлтгэсэн сэтгүүлчийг дэмжих, урамшуулах оновчтой механизм байгаа тохиолдолд олон нийтийн сэтгэл зүйд нөлөөлж чадахуйц сайн нийтлэл, нэвтрүүлэг гарах боломжтой юм.

Дөрөвдүгээрт, манай оронд чөлөөт хэвлэлийг эрхлэн гаргаж байсан туршлага, бэлэн боловсон хүчин байгаагүйгээс хэвлэл мэдээллийн хэрэгслийг эрхлэн гаргагчдын ч,

сэтгүүлч уран бүтээлчдийн ч, хүлээн авагчдын ч чөлөөт сэтгүүл зүйн талаарх мэдлэг, ойлголт ихээхэн дутмаг байсан нь өнөөдөр хүртэл нэг мөр болж, бүрэн цэгцэрч чадаагүй байна. Тиймээс хэвлэл мэдээллийг зөвхөн мөнгөний нүдээр харах, ашиг орлогыг ямагт нэгдүгээр байранд тавих, олон нийтийн эрх ашгийг үл хайхрах хандлага амь бөхтэй оршсоор байна. Тиймээс бараг бүх хэвлэл мэдээллийн хэрэгсэл чанартай, сайн аналитик материал бэлтгэхээс илүү дуулиан шуугианы шинжтэй үйл явдал, баримт мэдээлэлд илүү их анхаарал хандуулж, нийгмийн сэтгэл зүйгээр тоглохыг чухалчилдаг болсон. Үүнийг өдөр тумын чанартай сонинуудаас эхлээд гудамжны “шар” сонин хүртэлх бараг бүх мэдээллийн хэрэгслээс ажиглаж болно.

Тавдугаарт, манай орны нийт иргэд, түүний дотор хэвлэл мэдээллийн ажилтнууд ихээхэн улстөржсөн нь тод ажиглагддаг. Үүнийг бидний судалгаа хийсэн өдөр тутмын сонинуудын нийт материалын 1/5 нь, телевизийн мэдээллийн нэвтрүүлгийн тал хувийг улс төрийн асуудалтай холбоотой мэдээ, материал эзэлж байгаагаар тайлбарлаж болно. Ийм улс төрийн асуудлыг сонин, телевиз болгон өөр өөр өнцгөөс, өөрсдийн нийтлэл, нэвтрүүлгийн бодлого, чиглэлд тохируулан тайлбарлаж байгаагаас мэдээллийн тэнцвэрт байдал алдагдаж, жирийн хүлээн авагчдыг төөрөгдүүлэх, буруу зөрүү дүгнэлт хийх, заримдаа буруу шийдвэр гаргахад хүргэж байна.

Зургаадугаарт, аналитик сэтгүүл зүйд гол байр эзэлдэг бүтээлүүд бол эрэн сурвалжлах шинжтэй нийтлэл, нэвтрүүлэг бөгөөд сонгож авсан сэдэвт тал бүрээс нь дүн шинжилгээ хийж,

олж авсан баримт мэдээллийн шалтгаан, үр дагаврыг гаргаж, үндэс суурьтай дүн шинжилгээ хийхгүйгээр эрэн сурвалжлах шинжтэй бүтээл туурвих боломжгүй юм. Тиймээс судлаачид эрэн сурвалжлах нийтлэл, нэвтрүүлгийг аналитик сэтгүүл зүйд багтаадаг нь зүй ёсны хэрэг юм. Харамсалтай нь хэдийгээр манай оронд чөлөөт сэтгүүл зүйн эх суурь тавигдаад 20 гаруй жил өнгөрсөн боловч улс төрийн, эрх зүйн, сэтгүүлчдийн мэдлэг чадвар, ОНМХ-ийн менежмент, сэтгүүл зүйн сургалт-судалгаа зэрэг олон шалтгаантай холбоотой эрэн сурвалжлах сэтгүүл зүй зохих ёсоор хөгжиж чадахгүй байна. “Эрэн сурвалжлах” нэртэй цөөн тооны нийтлэл, нэвтрүүлэг алдаг оног гардаг боловч сонгож авсан сэдэвт хэт өнгөцхөн хандсан, асуудлын дотоод мөн чанарт нэвтэрч, учир шалтгааныг гаргаж чадаагүй, баримт мэдээлэл, эх сурвалж хангалтгүй, зохиогчийн хувийн үзэл бодол, хэмжээнээс хэтэрсэн үнэлэлт дүгнэлт давамгайлсан, хэт чамирахаж уран үгийн араас хөөцөлдсөн шинжтэй багаа нь түгээмэл юм. Энэ бол аналитик сэтгүүл зүйг хөгжүүлэхэд чөдөр тушаа болж буй нэг гол хүчин зүйл мөн.

Дээрх шалтгаан, хүчин зүйлс манай орон нутгийн, салбарын болон “шар” сонинуудыг эс тооцоход өдөр тутмын чанартай сонинуудад, нөлөө бүхий томоохон телевизүүдэд аналитик нийтлэл, нэвтрүүлэг эрс багасахад нөлөөлж байна. Өдөр тутмын “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Зууны мэдээ”, “Улс төрийн тойм”, “Ардчилал” зэрэг таван сонины 2014 оны 12 дугаар сарын долоо хоногийн 30 дугаарыг шүүж үзэхэд аналитик шинжтэй тавхан материал нийтлэгдсэн нь үүний тод жишээ юм.

Тэр нийтлэлүүдийг сэтгүүл зүйн аналитик материалд тавигдах шаардлагын үүднээс авч үзвэл ихээхэн учир дутагдалтай, сонгож авсан асуудалд хэт өнгөцхөн хандсан, зохиогчийн хувийн дүгнэлт, үзэл бодол давамгалсан, асуудлын учир шалтгааныг илрүүлэх баримт дутмаг байгаа нь ажиглагдлаа. “Өдрийн сонин”-ы “Засгийн газар огцорсноор эдийн засагт ямар хохирол гарав?” (2014.11.28, №285) нэртэй асуудал хөндсөн өгүүлэлд зохиогч улс төрийн байдал тогтворгүй, засгийн газар огцорсны улмаас улс орны эдийн засаг улам хүндэрч, Оюу толгой, Таван толгой зэрэг хоёр том ордын хөрөнгө оруулалт саарч, хөрөнгө оруулагчийг шалгаруулах тендер сунжрах нь тодорхой болж, ажлаа эхэлсэн том том төслүүд зогсож, энэ бүхнээс шалтгаалан жирийн иргэдийн амьдрал улам хүндэрч эхэлсэн тухай чухал асуудлыг хөндсөн байна. Харамсалтай нь зохиогч эхнээс нь аваад уран гоё үгээр уянгалуулан, “...Лав л Ерөнхий сайдтай Оюу толгойн санхүүжилтийн асуудлаар яриа хөөрөө өрнүүлэх гэж байсан Дэлхийн банкны төлөөлөл ирэхээ больчихсон. Айлчлал нь хойшилсон гэх мэдээг “Блүүмбэрг”-ээр цацна лээ... Засаг эмхрээгүй учраас Оюу толгойн дөрвөн тэрбум ам. доллар лав энэ жилдээ орж ирэхгүй нь тодорхой болчихлоо. Бүр наашиллаа гэхэд ирэх оны зургадугаар сард магадгүй. Жилээс наашгүй гэдэг таамаг ч байна”, “Засгийн газар уначихаар гадаадын хөрөнгө оруулалт мөддөө орж ирэхгүй гэх гутранги таамаг хөвөрч байна”, “...Хайгуулын тусгай зөвшөөрлүүд өгч эхэлбэл дор хаяж хоёр тэрбум ам. доллар орж ирэх бололцоотой гэсэн таамаг бий”, “Засгийн газар эмхэрч амжаагүй учраас энэ ажил түр

зогсч таарна”, “Тендерт тавьсан шалгуураар бол “МАК”, “Энержи ресурс”-ын аль нэг нь гэсэн таамаг бий” гэх мэт цөөнгүй таамаглал дэвшүүлж, ямар ч эх сурвалжгүй баахан тоо баримт дурдсан нь уншигчийг итгүүлэн үнэмшүүлэх чадваргүй болгожээ. Бараг өгүүлбэр болгонд нэвт шингэсэн үзэл бодолд тулгуурлан “...дөрвөн тэрбум ам. доллар лав л энэ жилдээ орж ирэхгүй нь тодорхой болчихлоо”, “Энэ ордын хөрөнгө оруулагчийг шалгаруулах тендер сунжрах нь тодорхой боллоо”, “Юань, долларын ханш уралдан өсөөд байхаар эднийг олдог мөнгө улам бүр багасах нь тодорхой”, “Тэдний ажилгүй, орлогогүй өдрүүд ахиад өчнөөн сараар үргэлжлэх нь тодорхой болчихлоо”, “...Таван толгойн хөрөнгө оруулагчийг шалгаруулах асуудал хойшлох нь тодорхой”, “Засаг эмхэртэл энэ хэлэлцээр явагдахгүй зогсох нь ойлгомжтой”, “Ирэдийн хүлээх алдагдал тэр хэрээр нэмэгдэж байгаа нь тодорхой” гэх зэргээр дүгнэлт хийсээр байгаад дуусгажээ. Олдсон хэдэн баримтыг тоочсон, өнгөцхөн мэдээлсэн, эх сурвалж нь тодорхойгүй, зохиогчийн үзэл бодол, үндэслэлгүй дүгнэлт, хоосон таамаглал давамгайлсан нь илт байна.

Энэ бол судалгааны явцад бидний сонгож авсан бараг бүх материалд ажиглагдсан нийтлэг шинж юм. Уг нь аналитик нийтлэлийн зохиогч сонгож авсан үйл явдал, үзэгдэл, баримтын дотоод мөн чанарт нэвтэрч, учир шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлийг тодорлуулахын зэрэгцээ хүлээн авагчдад тусгаж буй баримтаар дамжуулан өөрөө дүгнэлт хийх боломж олгох учиртай юм.

Судалгааны дүнг үндэслэн дээр дурдсан дутагдал дараах хэдэн

шалтгаантай холбоотой гэж үзэх үндэстэй юм. Нэгдүгээрт, зохиогч бичиж, бэлтгэж буй аналитик шинжтэй нийтлэл, нэвтрүүлгийн зорилгоо оновчтой тодорхойлж, зөв чиг баримжаатай болж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, тухайн материалаар дамжуулан хүлээн авагчдад юу өгөх вэ, ямар үр дүнд хүрэх вэ гэдгийг төсөөлж чадахгүй байна гэсэн үг. Бүр тодруулж хэлбэл аналитик сэтгүүл зүйн үндсэн зорилго нь бодит байдлын янз бүрийн үзэгдлүүдийн хоорондох шалтгаан, үр дагаврын харилцааг илрүүлэх (1), аналитик эх бичвэрт тусгаж буй үйл явдал, үзэгдлүүд хувь хүн, хэсэг бүлэг, нийгмийн хувьд ямар ач холбогдолтой вэ гэдгийг тайлбарлах (2), судалж буй үзэгдлийн хэтийн төлвийн загварыг гаргаж, тэдний хүрч болох үр дагаврыг таамаглах (3), судалж буй үзэгдлүүдтэй холбоотой авч болох арга хэмжээ, шийдвэрлэх арга замыг томъёолох, эрж хайхад (4) оршино гэдгийг мэдэж байх шаардлагатай юм. Ийм мэдлэг, мэдээлэл, чадвар дутмаг байгаа тохиолдолд сайн аналитик нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэх боломжгүй юм.

Хоёдугаарт, тусгах судлагдахууныг зөв тодорхойлж, тэр нь “танин мэдэхүйн объектээс юугаар ялгаатай вэ”² гэдгийг оновчтой илэрхийлж чадахгүй байна. Орчин үеийн олон нийтийн мэдээллийн харилцааны шинжлэх ухаанд тусгах судлагдахууныг тодорхойлох ерөнхий онолын, үйл ажиллагааны гэсэн хоёр үндсэн хандлага бий. Тэд нэг нь нөгөөгөө үгүйсгэхгүй, харин харилцан уялдаа холбоонд оршиж, нэгийн дутууг нөгөө нь гүйцээж байдаг онцлогтой. Бас хоорондоо мэдэгдэхүйц ялгаа байна. Орчин үеийн сэтгүүл зүйн онолд бодит байдлыг таньж мэдэх

сэтгүүл зүйн судлагдахуун нь нийгмийн цаг үеийн чухал асуудал (байдал) гэж үздэг³. Энэ тохиолдолд нийгмийн чухал асуудал гэдэг нь нийгмийн бодит байдлын боломжит бүхий л илрэлүүдийг хамардаг нь тодорхой. Тиймээс тусгах судлагдахуун гэдэг нь нийгмийн тухайн үеийн нөхцөл байдалтай нягт харилцан холбоотой оршдог бүх үйл явдал, үйл явц мөн. Энэ нь сэтгүүлчийн бүтээж буй аналитик эх бичвэрийн танин мэдэхүйн судлагдахууныг оновчтой тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Хэрэв сэтгүүлч өөрийнхөө сонирхож буй бүх зүйлээ хүний үйл ажиллагааны илрэл гэдгийг анхаарлын төвд байлгасан нөхцөлд улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын салбарт өрнөж байгаа үйл явдал, үйл явц, нөхцөл байдлыг улам гүнзгий судлах боломжтой. Тийм учраас сэтгүүлч сонгож авсан судлагдахуунд аль өнцгөөс хандах вэ гэдгийг сайн мэдэх шаардлагатай юм.

Гуравдугаарт, сэтгүүлчид сонгож авсан сэдэв, судлагдахуунд дүн шинжилгээ хийх судалгааны болон танин мэдэхүйн энгийн аргуудын талаарх мэдлэг дутмаг байгаагаас, тухайн нөхцөлд чухам ямар аргыг сонгох вэ гэдгийг мэдэхгүй байна. Энд аргуудын талаар ялимгүй дэлгэрүүлж өгүүлэх шаардлагатай. Аналитик сэтгүүл зүйд сэтгүүлчийн уран бүтээлийн бүх төрөлд хэрэглэдэг аргуудыг ашиглаж болно. Ийм аргуудыг туршилтын буюу мэдээлэл цуглуулах аргууд, онолын буюу цуглуулсан баримт мэдээллүүдийг боловсруулах аргууд гэсэн хоёр том хэсэгт хувааж үздэг. Туршилтын аргуудад ажиглалт, ярилцлага, баримт бичигтэй ажиллах, туршилт хийх, анкетийн асуулга явуулах зэрэг арга багтдаг бол онолын

аргуудад задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх (анализ ба синтез), логикийн болон түүхчлэн үзэх арга, таамаглал дэвшүүлэх, нэгжээс ерөнхий руу, ерөнхийгөөс нэгж руу орох, адилтгах, харьцуулах (индукц, дедукц, традукц) зэрэг арга багтдаг. Ер нь аналитик сэтгүүл зүйд онолын аргуудыг идэвхтэй ашиглахгүйгээр амжилтанд хүрэх боломжгүй. Энэ аргуудыг хэрэглэнэ гэдэг бол сэтгүүлч тодорхой хэмжээгээр судлаачийн хэмжээнд ажиллана гэсэн үг юм. Мэдээллийг боловсруулах явцад сэтгүүлч дээр дурдсан аргуудаас гадна үндэслэлээ хамгаалах, нотлох, маргаан өрнүүлэх, няцаалт өгөх, үзүүлэн тайлбарлах зэрэг аргуудыг хэрэглэх бүрэн боломжтой бөгөөд энэ нь зохиогчийн зорилго, сонгож авсан сэдвээс ихээхэн шалтгаалах болно. Энэ утгаар нь авч үзвэл бодит байдлыг аналитик аргаар тусгах нь чанартай ОНМХ-ийн стратеги хүчин зүйл болдог онцлогтой юм. Тиймээс сэтгүүлч бидний дээр дурдсан аргуудын талаар тодорхой мэдлэгтэй, тэднийг оновчтой хэрэглэх дадал, чадвар эзэмшээгүй нөхцөлд сайн аналитик нийтлэл, нэвтрүүлгийн талаарх яриа байж болохгүй гэдэг нь тодорхой. Өнөөдөр манай сэтгүүч уран бүтээлчдэд чухам энэ мэдлэг, чадвар дутагдаж байгаа нь нууц биш юм.

Дөрөвдүгээрт, аналитик нийтлэл, нэвтрүүлгийн сэдвийг ямар шалгуураар сонгох вэ гэдгийг сайн мэдэхгүй байна. Тиймээс онцын шаардлагагүй, нийгмийн ач холбогдол багатай, олон нийтийн эрх ашигт тэр бүр нийцээгүй, цаг үеэ олоогүй сэдвийг сонгон авч цаг алдах, багагүй хүч хөдөлмөр зарцуулах явдал түгээмэл юм. Сэтгүүлч юуны өмнө тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн бодлого чиглэлд тохирч буй эсэх, сэдвийн цаг

үеэ олсон байдал, нийгмийн ач холбогдол, сонгож авсан асуудал, үйл явдлын хамрах хүрээ, шинэлэг тал, хүлээн авагчдын сэтгэл зүйд нөлөөлөх түвшин, тэдэнд сэтгэл зүйн хувьд ойр байх боломж зэрэг наад захын шалгууруудыг харгалзан үзэх ёстой.

Орчин үеийн мэдээлэл технологийн үр дүнд сэтгүүл зүй эрчимтэй даяаршиж, мэдээлэл нь агуулга ба хэлбэр, тусгах арга барилын хувьд хурдацтай өөрчлөгдөж, ОНМХ-ийн өмнө асар том зорилтуудыг тавьж, тэднийг богино хугацаанд оночтой шийдвэрлэхийг шаардах болсон. Өнөөдөр сэтгүүлч юу бичих вэ гэдгийг ХМХ-ийн эзэд, дарга нар биш хүлээн авагчид мэддэг болсон, өөрөөр хэлбэл олон нийтийн мэдээллийн хэрэгцээ, шаардлагыг судлахгүйгээр, тэдний хүсэн хүлээж буй зүйлийн талаар төсөөлөлгүйгээр амжилттай ажиллах боломжгүй юм. Ямар ч иргэн болж байгаа үйл явдал, үзэгдэл, баримтын талаар сэтгүүлчээс түрүүлж мэдээлэх, сэтгүүлчийн үүргийг гүйцэтгэх боломжтой орчин үед ХМХ шуурхай мэдээллээс илүү аналитик материалд онцгой анхаарч, түүнийг чанарын өндөр түвшинд бэлтгэх нь цаг үеийн шаардлага, ялангуяа тогтмол хэвлэлийн өмнө тавигдаж буй хамгийн чухал зорилтуудын нэг болон хувирсан. Сэтгүүлч орчин үеийн сэтгүүл зүйн хөгжлийн энэхүү зүй тогтол, дотоод хуулийн талаар тодорхой мэдлэг, төсөөлөлгүй ажиллах ямар ч боломжгүй юм. Тиймээс аль ч хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ажиллаж буй сэтгүүлч үүнийг онцгой анхаарах шаардлага тулгарч байна.

Энэ бүхнээс үзэхэд аналитик сэтгүүл зүйг эрчимтэй хөгжүүлж, түүнийг чанарын шинэ шатанд гаргах нь зөвхөн монголын сэтгүүл зүй төдийгүй дэлхий

дахины сэтгүүл зүйн өмнө тавгдаж буй цоо шинэ зорилт, тулгамдсан асуудлын нэг бөгөөд мэдээллийн эрин зуунд хөл тавьж, мэдээллийн нийгэм байгуулж байгаа манай орны сэтгүүл зүй үүний гадна үлдэж болохгүй гэдэг нь тодорхой юм. Манай орны сэтгүүл зүйд өнөөдөр эрэн сурвалжлах, иргэний, өмгөөллийн, экологийн, уул уурхайн, эдийн засгийн зэрэг сэтгүүл зүйн бараг бүх чиглэл ямар нэг хэмжээгээр оршин тогтнож, янз бүрийн түвшинд үйл ажиллагаа явуулж байна. Харин аналитик сэтгүүл зүйн орон зай үгүйлэгдэж байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тиймээс үүнд тогтмол хэвлэл, радио, телевиз, цахим мэдээллийн хэрэгслийн аль аль нь онцгой анхаарах шаардлага тулгарч байна.

Ишлэл

- ¹ Тертычный А.А. 2010. Аналитическая журналистика. М., с.3.
- ² Там же. с.31.
- ³ Лазутина Г.В. 2000. Основы творческой деятельности журналистики. М., с.71.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Акопов А.И. 1996. Аналитические жанры журналистики. Ростов-на-Дону.
2. Баасансүрэн Т. 1999. Сэтгүүлчийн ур чадварын тухай яриа. УБ.
3. Зулькафиль М. 2015. Орчин үеийн Монголын сэтгүүл зүй. УБ.
4. Зулькафиль М. 2017. Орчин үеийн Медиа: шинэчлэл, чиг хандлага. УБ.
5. Зулькафиль М. 2017. Сэтгүүлчийн хөдөлмөр: ёс зүй, хариуцлага, үнэлэмж. УБ.
6. Лазутина Г.В. 2005. Основы творческой деятельности журналистики. М.
7. Норовсүрэн Л. 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ.
8. Тертычный А.А. 2010. Аналитическая журналистика. М.

9. Черных А. 2004. Мир современных Медиа. М.

Резюме

В статье впервые рассматриваются теоретико-практические вопросы аналитической журналистики Монголии. Автор анализируя публикации некоторых ежедневных газет показывает их недостатки и влияющие на них причины.

Автор считает, что современные СМИ Монголии страдают чрезмерной поверхностью в отображении действительности и причинами которых являются ограничение лишь описанием и фиксацией фактов, отсутствие связи между событиями, явлениями и следствиями, изменениями в реальной жизни, погоня за сенсациями и развлекательность.